


# “ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК-ИЙН САЛХИТЫН УУРХАЙН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ ТӨСЛИЙН МЭДЭЭ

Дугаар 16 2023 оны 2-р сар

## УУРХАЙН ХААЛТЫН ӨРТӨГ ЗАРДАЛ ТООЦООЛОХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



Зураг 1. Уурхайн хаалтын өртөг зардал тооцоолох хэлэлцүүлэг

Хаалтын өртөг зардал тооцоолох ажлын хүрээнд багийн эхний хэлэлцүүлгийг 2023 оны хоёрдугаар сарын 8-ны өдөр зохион байгуулав. Уг цуврал хэлэлцүүлгийн үр дүнд Салхитын хаалтын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах бүх төрлийн зардлыг аль болох бодитоор тооцоолж “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-д хүргүүлэх болно. Хэлэлцүүлгийн үеэр Зардал тооцооллын зөвлөх баг ашиглаж буй тооцооллын аргачлал болон төлөвлөлтийн багийн зөвлөхүүдээс чиглэл тус бүрээр ямар мэдээлэл, тоо баримт шаардлагатайг тайлбарлав. Түүнчлэн төлөвлөлтийн баг болон “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ийн холбогдох мэргэжилтнүүд, санхүүгийн ажилтанд зардал тооцоолоход анхаарах шалгуур үзүүлэлтүүдийг танилцуулж, хэлэлцүүлэв. “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ийн санхүүгийн алба хаалтын зардал тооцоолох ажлын бүх үе шатанд оролцож, үндэсний зөвлөх багтай нягт хамтран ажиллана. Хаалтын зардал тооцоолоход дахин гурван удаагийн багийн хэлэлцүүлгийг хоёр, гуравдугаар сард зохион байгуулж, дөрөвдүгээр сарын сүүл гэхэд эцэслэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Зардлын нарийвчилсан тооцооллыг

“Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ийн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад танилцуулж батлуулах юм. Өртөг зардлын тооцоолол хаалтын төлөвлөгөөний нэг бие даасан бүлэг болж буй онцлогтой.

## ЖИШИГ ТӨСЛИЙН ГОЛ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН УУЛЗАЛТ

Салхитын уурхайн Хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах жишиг төслийн оролцогч талуудын ээлжит уулзалт 2023 оны хоёрдугаар сарын 7-ны өдөр боллоо. Энэ удаагийн уулзалтаар оролцогч талуудад төслийн хэрэгжилт, төлөвлөсөн ажлуудын талаар мэдээлэл өгч, Салхитын ордын Хаалтын менежментийн төлөвлөгөөг цаашид тогтвортой хэрэгжүүлэхэд анхаарах алхмууд, болон газар хэлбэршүүлэлтийн зураг төсөл болон нутгийн иргэдийг уурхайтай танилцуулах “Мэдээлэл солилцох өдөрлөг”-ийн үр дүнг тус тус танилцуулав.

Хаалтын газар хэлбэршүүлэлтийн инженерийн зураг төслийг нөлөөлөлд өртсөн талбайг байгалийн унаган төрхөд ойртуулж, нутгийн иргэдийн уламжлалт газар ашиглалтад нийцүүлэн нөхөн сэргээх хэмээн жишиг төслийн эхний үе шатанд тодорхойлсон хаалтын үндсэн хоёр зорилгод нийцүүлэн боловсруулаад байна. Чингэхдээ уурхай хаагдсаны дараа нөхөн сэргээсэн газар нутаг урт хугацаанд тогтвортой үр өгөөж бий болгоход анхаарч, сүүлийн таван сарын хугацаанд хаалтын төлөвлөлтийн багийн нарийн мэргэжлийн зөвлөх тус бүрийн саналыг тусгаж боловсруулав. Уулзалтын үеэр газар хэлбэршүүлэлтийн инженерийн зураг төслийг оролцогч талуудад танилцуулж, санал зөвлөмжийг нь сонсов.



Зураг 2. Жишиг төслийн гол оролцогч талуудын 2023 оны 2-р сарын уулзалтад оролцсон төлөөлөл

Нутгийн иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор хоёр дахь удаагаа зохион байгуулсан “Мэдээлэл солилцох өдөрлөг”-ийн үеэр иргэдийн дэвшүүлсэн санал санаачилга, ажлын үр дүнд “ЭСР ХХК-ийн төлөөлөл танилцуулав. Мэдээлэл өгөх өдөрлөгийг хоёр удаа зохион байгуулсны үр дүнд компани, ард иргэдийн харилцан ойлголцол, мэдээлэл ихээхэн сайжирсныг онцолж байв. ЭСР ХХК иргэдийн дуу

хоолойг сонсож, оролцоог хангадаг сайн туршлагыг компанийн олборлох болон хаалтын үе шатанд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээ илэрхийлэв.

Нээлттэй хэлэлцүүлгийн үеэр оролцогчид жишиг төслийн онцлох үр дүнг дурдав. Тухайлбал, уурхайн хаалтын төлөвлөлтийн үйл ажиллагаанд нутгийн иргэдийн оролцоог хангаж, тогтмол мэдээлэл өгснөөр гарч буй зэрэг үр дүнд, иргэдийн мэдлэг дээшилсэн байдал, үндэсний зөвлөхүүд, компанийн ажилтнууд, төрийн албан хаагчдын чадавх бэхжиж буйг онцлов. Мөн компанийн зүгээс уурхайг хаахын тулд хангалттай төсөв хөрөнгийг урьдчилан төлөвлөж хуримтлуулах нь чухал хэмээн санал нэгдэв. Түүнчлэн орон нутгийн оролцогч талууд уурхай хаасны дараа уурхайн барилга байгууламж, дэд бүтцийг ашиглан эдийн засгийн боломжуудыг бий болгох хүсэлтэй байгаагаа уламжлав.

## ■ САЛХИТЫН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЦААШДЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР “ЭРДЭНЭС МОНГОЛ” ХХК-ИЙН УДИРДЛАГУУДТАЙ УУЛЗАЖ, МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭВ



**С. Наранцогт**  
“Эрдэнэс Монгол” ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал

Салхитын уурхайн Хаалтын менежментийн төлөвлөгөөг цаашид тогтвортой хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох үүднээс төслийн баг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн удирдлага, шийдвэр гаргагч нартай хамтран ажиллахад анхаарал хандуулж байна. Компанийн дээд удирдлагын төвшинд ойлголтыг бэхжүүлэх, хамтын ажиллагааг хангах нь хаалтын төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх, цаашид компани бие даан шинэчлэн сайжруулахад ихээхэн ач холбогдолтой юм.

MERIT төсөл “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Наранцогт, Зэс, металлын группийн дарга Х.Бадамсүрэн нартай тус бүр уулзаж, жишиг төслийг танилцуулах, байгууллагын тогтвортой стратегийг хангах талаар мэдээлэл солилцов.

Уулзалтын үеэр “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Наранцогт уурхайн хаалтыг эртнээс төлөвлөх нь уурхайн төсөл хэрэгжүүлэгчийн хувьд байгаль орчин, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэхэд нэн чухал ач холбогдолтойг онцолж байв. Түүнчлэн компанийн хувьд Салхитын уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн зардлыг урьдчилан төлөвлөж, хуримтлуулахад анхаарч ажиллахаа илэрхийллээ.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Зэс, металлын группийн дарга Х.Бадамсүрэн мөн ижил байр суурь илэрхийлж, уурхайн хаалтын жишиг туршлагыг амжилттай хэрэгжүүлэх нь “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ны хувьд эдийн засгийн ихээхэн хэмнэлт гаргах үр ашгийг авчрах төдийгүй төрийн өмчит компанийн хувьд хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагааг хөгжүүлэхэд түүчээлэх том боломж хэмээн харж буйгаа онцолсон. Мөн “Эрдэнэс Монгол” ХХК-ны холбогдох ажилтнуудыг жишиг төслийн арга хэмжээнд оролцуулж, олон улсын тэргүүн туршлагаас суралцуулах нь бусад охин компанийн хаалтын төлөвлөгөөг боловсруулах чадавхыг бий болгох ач холбогдолтой хэмээв.

## ■ ХААЛТЫН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭ ТОДОРХОЙЛОХ БАГИЙН АЖИЛ


Төлөвлөлтийн багийн мэргэжилтнүүд Салхитын уурхайн хаалтын нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийг үнэлэх хүрээ, хяналт-шинжилгээний шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох зорилгоор нийт гурван удаагийн багийн хэлэлцүүлгийг зохион байгуулав. Олон улсын техникийн зөвлөх Канадын Алберта мужид ижил төстэй төслүүдийн хаалтын төлөвлөгөө боловсруулахад оролцсон туршлагын дагуу хяналт-шинжилгээний шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулав.



**Зураг 3.** Төлөвлөлтийн багийн мэргэжилтнүүд хяналт-шинжилгээний хүрээ тодорхойлохоор багаар ажиллаж буй нь

Хаалтын ажлын гүйцэтгэлийг үнэлэхийн тулд нөхөн сэргээлтийн төлөвлөлт, хяналт-шинжилгээний нарийвчилсан мэдээллийг тусгасан зорилго, зорилт, шалгуур, шалгуур үзүүлэлт бүхий хяналт шинжилгээний хүрээг тодорхойлох шаардлагатай. Эрэмбэ дарааллыг зураг 4-с харна уу.

Жишиг төслийн эхний шатанд хаалтын үндсэн хоёр зорилго боловсруулсан бөгөөд тус зорилгуудад чиглэсэн уурхайн хаалтын хяналт-шинжилгээний ажлыг тодорхойлох нь чухал юм. Эдгээр зорилго, холбогдох зорилтууд нь уурхайн хаалтын алсын харааг тодорхойлно.



**Зураг 4.** Зорилго, зорилт, шалгуур, шалгуур үзүүлэлтүүдийн эрэмбэ дарааг харуулсан хаалтын хяналт-шинжилгээний хүрээ. Эх сурвалж: “Си Пи Пи Энвайронментал” корпораци

Нөхөн сэргээлтийн үр дүнг үнэлэхдээ хүн ам, хүрээлэн буй орчинд үзүүлэх аюулгүй байдал, газар хэлбэршүүлэлтийн физик, химийн тогтвортой байдал, нийгэм-эдийн засгийн шилжилт, экологийн тогтвортой байдал/нөхөн сэргээлт, эрсдэлийн менежмент зэрэг хаалтын сайн туршлагын зарчмуудыг авч үздэг. Эдгээрийг Салхитын уурхайн хаалтын хяналт-шинжилгээний хүрээг гаргасан эхний хувилбарт тусгасан болно.

Олон улсын техникийн зөвлөх төлөвлөлтийн багийн хэлэлцэж, боловсруулсан шалгуур үзүүлэлтүүдийг хяналт-шинжилгээний хүрээнд тусгахаар ажиллаж байна. Гуравдугаар сарын эхээр төлөвлөлтийн баг шалгуур үзүүлэлтүүдийн бүрэн боловсруулсан, сүүлийн хувилбарыг гаргаж “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-д танилцуулна.

### ХОЛБОО БАРИХ

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Төслийн захирал **Р.Алтангэрэл**тэй имэйл хаягаар холбогдоно уу.  
r.altangerel@merit.mn

Бид та бүхэнд Салхитын уурхайн хаалтын мэдээ мэдээллийг аль болох сонирхолтой байдлаар хүргэхийг зорьдог билээ. Төслийн оролцогч талуудын санал, сэтгэгдлийг сонсож, бэлтгэж буй мэдээ мэдээллийг уншигчдын хэрэгцээ, сонирхолд нийцүүлэх нь чухал юм. Тиймээс та бүхэн төслийн сар тутмын мэдээтэй холбоотой санал сэтгэгдлээ бидэнтэй хуваалцана уу.